- НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН
- НЭГЖ ТАРИФ

- ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

# Хууль, эрх зүйн үндэслэл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ

/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

**9 дүгээр зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын Зөвлөл, хотын Захирагчийн бүрэн эрх**

9.1.3.энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;

9.1.4.энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах;

# Хууль, эрх зүйн үндэслэл

САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 192, А/243 | Улаанбаатар хот

АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хог хаягдлын тухай хуулийн 9.1.4-т заасны дагуу нутаг дэвсгэртээ мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батална.

1.2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хог хаягдлын тухай хуулийн 9.2.1-т заасны дагуу нутаг дэвсгэртээ мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх нэгж тарифыг батална.

3.1.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх зардлыг тооцох аргачлал

| Үзүүлэлтүүд | | Нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| A | Нэг өдөрт цэвэрлэх талбайн хэмжээ | өдөр/$м^2$ | Ажлын зураг авалтаар тодорхойлох |
| B | Нэг өдөрт зарцуулах багаж хэрэгслийн зардал | Өдөр/төг | Сүүлийн 3-н жилийн дунджаас тооцох |
| C | Ажилтны нэг өдрийн цалин | Өдөр/төг | Нэг сарын үндсэн болон нэмэгдэл цалингаас тооцох |
| D | Ажиллах хүчний задал | Өдөр/төг | D=B+C |
| E | Нэг $м^2$ талбайг цэвэрлэхэд шаардагдах зардал | $м^2$ | E=A/D |

Нийтийн эзэмшлийн **648,527мкв** авто зам, **149,990мкв** явган хүний зам, **24,796 мкв** дугуйн зам нийт **787,099** мкв замын цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр тогтмол хийж замын хөдөлгөөний аюулгүй байдал, иргэдэд эрүүл аюулгүй цэвэр орчинг бүрдүүлэн ажиллаж байна.











# A. Нэг өдөрт цэвэрлэх талбайн хэмжээ /ажлын зураг авалтаар/








# В. Нэг өдөрт зарцуулах багаж хэрэгсэл




**Багаж хэрэгслийн зардлыг сүүлийн 3 жилийн дундаж зардлаас тооцсон.**

# 3%. Нэг өдөрт нэг ажилтан ногдох багаж, хэрэгсэл



| Нэр төрөл | Олгох тоо /сараар/ | Өртөг хүн/өдөр |
|---|---|---|
| Дэрсэн шүүр | 2 ширхэг | 1028 төгрөг |
| Зуны бээлий | 4 ширхэг | 160 төгрөг |
| Өвлийн бээлий | 1 ширхэг | 100 төгрөг |
| Хүрз | 0,5 ширхэг | 342 төгрөг |
| Цасны хүрз | 0,5 ширхэг | 334 төгрөг |
| Жоотуу | - | 107 төгрөг |
| Аюулгүйн тэмдэг | - | 125 төгрөг |
| Маск, гар угаах саван ... | 1 ширэг | 1012 төгрөг |
| **Нийт** | **3208 төгрөг** | |

**ЖИЧ: Дэрсэн шүүр, хүрз, бээлий зэрэг багаж хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа. Нормыг даргын тушаалаар баталж төсөвт багтаан олгодог.**

# 4%. Нэг өдөрт нэг ажилтан ногдох хөдөлсөр, хамгааллын зардал



| Нэр төрөл | Олгох тоо /сараар/ | Өртөг хүн/өдөр |
|---|---|---|
| Зуны хувцас | 0,5 ширхэг | 660 төгрөг |
| Өвлийн хувцас | 0,5 ширхэг | 1065 төгрөг |
| Шар хантааз | - | 157 төгрөг |
| Өвлийн гутал | 0,5 | 1044 төгрөг |
| Усны гутал | - | 855 төгрөг |
| Эм, бэлдмэл | - | 42 төгрөг |
| Аарц, чацаргана, сүү ... | - | 177 төгрөг |
| | | |
| **Нийт** | **4000 төгрөг** | |

# 87%. Машин механизм /шатахуун, сэлбэг хэрэгсэл, давс бодис ... /



| Нэр, төрөл | Зардал /өдрөөр/ |
|---|---|
| Шатахуун, тослох материал | 74812 төгрөг |
| Давс, бодис, хайрга | 1313 төгрөг |
| Сэлбэг | 18801 төгрөг |
| НИЙТ | 94926 төгрөг |







ЖИЧ:Тээврийн хэрэгслийн элэгдэл хорогдлын зардлыг тооцоогүй болно

# В. Нэг өдөрт ногдох ажилтны цалин



| Нэр, төрөл | Зардал /өдрөөр/ |
| --- | --- |
| Дундаж цалин | 68077 төгрөг |
| Хоол, унааны зардал | 8000 төгрөг |
| Нөхцөлийн нэмэгдэл | 4061.47 төгрөг |
| Илүү цагийн нэмэгдэл | 10600 төгрөг |
| Ур чадварын нэмэгдэл | 3412.53 төгрөг |
| | |
| НИЙТ | 94151 төгрөг |

# НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

| Үзүүлэлт | | Нэгж | Хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Нэг өдөрт цэвэрлэх талбайн хэмжээ | өдөрт/м2 | 8,000 | Зам талбайн 1 үйлчлэгч өдөрт 8000 м2 буюу сард 169,600 м2 /Төв зам, туслах зам, дугуйн болон явган хүний зам, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэдэг/ |
| 2. | Нэг өдөрт зарцуулах багаж хэрэгсэл | өдөрт/төг | 108,741 | Сүүлийн 3 жилийн дундаж хэмжээгээр тооцсон.<br>Багаж хэрэгсэл /дэрсэн шүүр, бээлий, хүрз гэх, мэт/ - 3,208 төгрөг<br>Хөдөлмөр хамгааллын нормын хувцас, гутал /өвөл, зун/ - 4,000 төгрөг<br>Машин, механизмын зардал /шатахуун, сэлбэг хэрэгсэл, давс бодис .../ – 94,926 төгрөг<br>Бусад зардал / ХАБЭА сургал, эрүүл мэндийн үзлэг...../-6,607 төгрөг |
| 3. | Ажилтны нэг өдрийн цалин | өдөрт/төг | 94,151 | Дундаж цалин – 68,077 төгрөг<br>Хоол, унааны зардал – 8,000 төгрөг<br>Нөхцөлийн нэмэгдэл – 4,061.47 төгрөг<br>Илүү цагийн нэмэгдэл – 10,600 төгрөг<br>Ур чадварын нэмэгдэл – 3,412.53 төгрөг |
| 4. | Ажиллах хүчний зардал | өдөрт/төг | 202,892 | 4=2+3 |
| 5. | Нэг м2 талбайг цэвэрлэхэд шаардагдах зардал | М2/төг | **25** | 5=4/1 |

3.1.3. Энгийн хог хаягдлыг булшлах зардлыг тооцох аргачлал

| | Үзүүлэлтүүд | Нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| A | Өдөрт дарж булах хогийн хэмжээ | Тн | Сүүлийн 3-н жилийн дундаж хэмжээнээс тооцох |
| B | Өдөрт ажиллах цаг | Цаг | ажлын зураг авалтаар |
| C | Нэг цагт зарцуулах шатахууны норм | Цаг/л | Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг нормыг үндэслэн тооцох |
| D | Шатахууны үнэ | Төг/л | Тухайн үеийн зах зээлийн үнэ |
| E | Нэг өдөрт зарцуулах шатахуун | Өдөр/төг | E=(B*C)*D |
| F | Ажилтны нэг өдрийн цалин | төг | Ажилтны нэг сарын үндсэн болон нэмэгдэл цалингаас тооцох |
| G | Нэг өдөрт ажиллах ажилтны тоо | Тоо | Ажлын зураг авалтаар тодорхойлох |
| H | Ажлын багаж хэрэгсэл | Өдөр/төг | Сүүлийн 3-н жилийн дундаж зардлаас тооцох |
| I | Элэгдлийн зардал | Өдөр/Төг | Элэгдлийн зардлыг тооцох |
| J | Засвар үйлчилгээний зардал | Өдөр/Төг | Сүүлийн 3-н жилийн дундаж зардлаас тооцох |
| K | Ажиллах хүчний зардал | Өдөр/төг | K=F*G+(H+I+J) |
| L | Нэг тонн хог хаягдлыг дарж булах зардал | тн/төг | L=(E+K)/A |

Дархан хотын 23,000 гаруй айл өрх, 1186 аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ачиж, цуглуулах, тээвэрлэх, дарж булшлан устгах үйл ажиллагааг эрхэлж байна.









# ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

| № | Үзүүлэлтүүд | Нэгж | Хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| A | Өдөрт дарж булах хогийн хэмжээ | Тн | 178.39 | 2022 он – 171.97 тн<br>2023 он – 178.39 тн<br>2024 он – 184.82 тн |
| B | Өдөрт ажиллах цаг | Цаг | Бульдозер /Т-160-3HW/ - 8<br>Эксковатор /HX300SL/ - 6<br>Хово – 6<br>Ковш /LT955/ - 4 | Ажлын зураг авалт хийгдсэн. |
| C | Нэг цагт зарцуулах шатахууны норм | Цаг/л | Бульдозер /Т-160-3HW/ - 21.5<br>Эксковатор /HX300SL/ - 20..74<br>Хово – 21.2<br>Ковш /LT955/ - 22.5 | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан норм |
| D | Шатахууны үнэ | Төг/л | 3,200 төгрөг | Зах зээлийн үнэ. |
| E | Нэг өдөрт зарцуулах шатахуун | Өдөр/төг | 1,643,648 төгрөг | Бульдозер /Т-160-3HW/ - 550400 төгрөг<br>Эксковатор /HX300SL/ - 398208 төгрөг<br>Хово – 407040 төгрөг<br>Ковш /LT955/ - 288000 төгрөг |
| F | Ажилтны нэг өдрийн цалин | төг | 449,355 төгрөг | Ховоны жолооч – 94863<br>Оператор – 111164*3 = 354942<br>/Үндсэн цалин, хоол унаа, нөхцлийн нэмэгдэл/ |
| G | Нэг өдөрт ажиллах ажилтны тоо | Тоо | 4 ажилтан | Ажлын зураг авалтаар хийсэн. |
| H | Ажлын багаж хэрэгсэл | Өдөр/төг | 8375.10 | Сүүлийн 3 жилийн дундаж зардлаас тооцсон |
| I | Элэгдлийн зардал | Өдөр/Төг | 401,689 | Шулуун шугамын аргаар тооцоолсон |
| J | Засвар үйлчилгээний зардал | Өдөр/Төг | 18,343 | 3 жилийн дунджаар бодсон |
| K | Ажиллах хүчний зардал | Өдөр/төг | 877,854 | K=F*G+(I+J) |
| L | Нэг тонн хог хаягдлыг дарж булах зардал | тн/төг | **14,350.0** | L=(E+K)/A |

## Улаанбаатар, бусад аймгуудын баталсан тариф

| № | Аймаг | Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх зардлын нэгж тариф | Энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф |
|---|---|---|---|
| 1 | *Улаанбаатар* | **70** | **6364** |
| 2 | *Дорнод* | **5** | **-** |
| 3 | *Хөвсгөл* | **10400** | **6400** |
| 4 | *Төв* | **9250** | **9213.26** |
| 5 | *Булган* | **9.4-11.4** | **12000-15000** |
| 6 | *Дорноговь* | **14.5** | **3753.5** |
| 7 | *Дундговь* | **9.4-11.4** | **10000-12000** |
| 8 | *Завхан* | **15** | **10000-15000** |
| 9 | *Өмнөговь* | **1.89** | **2348** |
| 10 | *Ховд* | **4** | **9131** |
| 11 | *Хэнтий* | **9** | **10000-15000** |
| 12 | *Дархан-Уул* | **25** | **14350** |

# ХОГ-Хэрэггүй эд, юмс бүхнийг хог хаягдал гэнэ

**Хог хаягдлыг шинж чанараар нь 2 ангилдаг**
*/Хог хаягдлын тухай хууль 2017 он/*

**Энгийн хог хаягдал**

**Аюултай хог хаягдал**

**Физик төлөв байдал:**
**1.Хатуу 2.Шингэн 3.Хий**

**Физик төлөв байдал:**
**1.Хатуу 2.Шингэн 3.Хий**

**Сумын дахиварын төв**
**Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд**
**(УБ хот Налайх, Төв аймгийн Сэргэлэн сум)**

**Сумын хогийн цэгт булшлагдана**
**/Ландфилл/**




Анаэробик бактерийн тусламжтайгаар метанаар баяжсан "биохий" буюу "намгийн хий" нь намагт газар, малын өтөг бууц, хогийн цэг зэрэгт үүснэ.
Метан (CH4), этан (C2H6), пропан (C3H8), бутан (C4H10), хүхэрт хий... гм
Шаталт, уугилт
Шингэн шүүрэл байнга үүсч нэвчин хөрс, гүний усыг бохирдуулж байдаг

# ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН МЕНЕЖМЕНТ

**Хог хаягдал эх үүсвэр:**
- Айл өрх
- Албан байгууллага
- Үйлдвэр, ААНБ

Дахивар цуглуулах

ААНБ ...

**Дахиварын тээвэр ложистикийн төв /хувийн хэвшил/:**

Тохижилт үйлчилгээний газар /ХТГ, ТҮК .../








Дахиварын олборлолт

**Дахин боловсруулах үйлдвэрүүд:**
20 гаруй үйлдвэр ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТЫН МЕХАНИЗМ




1. Хог хаягдлын менежментийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд ажлын гүйцэтгэл, үр дүнгээ гарган өгч, баталгаажуулж, санхүүжилтээ авна
2. Дахиварын санхүүжилтийг хог хаягдал цуглуулж, тээвэрлэх нэгж тарифаар тооцож олгоно.
3. Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага нь сар бүр дарж булсан хог хаягдлын хэмжээ, аймгийн ИТХ-аар батлагдсан нэгж тарифаар сумын ЗДТГ-аас санхүүжилтээ авна.

# Хууль эрх зүйн үндэслэл

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 340 | Улаанбаатар хот

**ХУВИЙН ХЭВШИЛ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.2, 17.1.3-т заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

2. Салбар болон орон нутгийн хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох чиг үүрэг, ажил үйлчилгээний чиглэлийг 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг энэ тогтоолын 1-д заасан хэлбэрээр гүйцэтгүүлэх болсонтой холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөлд зохих өөрчлөлтийг тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавханд тус тус даалгасугай.

3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

4. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих, зах зээл дээр төрийн оролцоо, хүнд суртлыг үе шаттай бууруулахад чиглэсэн бодлогын зөвлөмж, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

# Хууль эрх зүйн үндэслэл

## Байгал орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№ 25-08

Энэхүү гэрээг Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.11 дэх заалтыг тус тус үндэслэж нэг талаас **Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа** (цаашид "Сайд" гэх), нөгөө талаас **Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал** (цаашид "Засаг дарга" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) хамтран байгуулав.

НЭГ.ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа орон нутагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

9.3. Талууд энэхүү гэрээг 2026 онд шинэчлэн байгуулах ба гэрээнд тусгагдах ажлын саналыг 2025 оны 10 дугаар сарын 15-наас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны дотор багтаан солилцож авч 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор гэрээний төслийг боловсруулан, харилцан тохиролцсон байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД | ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА |
|---|---|
| С.ОДОНТУЯА | Б.АЗЖАРГАЛ |

4.8.Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1-9.3.13; 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.1-14.8, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1-16.9, 17 дугаар зүйлийн 17.1-17.7, 40 дүгээр зүйлийн 40.1-40.8, 41 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх

# Хууль эрх зүйн үндэслэл

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны 89 дүгээр тогтоол

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 16 өдөр Дугаар 89 Дархан

"Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
2022-2032"-ыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан хотын "Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө-2022-2032"-ыг хавсралтаар батлсугай.

2. "Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 2022-2032"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг хангуулан, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.НАСАНБАТ



# Хууль эрх зүйн үндэслэл

## Дархан-Уул аймгийн Засаг даргын 01-А/373 болон 01-А/16 захирамжууд

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар 01-А/373 Дархан

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Захирагчийн ажлын албаны дарга |
| | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Дархан сумын Засаг дарга |
| | Шарын гол сумын Засаг дарга |
| | Орхон сумын Засаг дарга |
| | Хонгор сумын Засаг дарга |
| | Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-ын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга |

2.Журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, батлуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ажлын хэсэг (П.Батсух)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр Дугаар 01-А/16 Дархан

### Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Дархан хотын Захирагчийн орлогч (хотын менежер) |
| Гишүүд: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| | Байгаль орчны газрын дарга |
| | Дархан сумын Засаг дарга |
| | Шарын гол сумын Засаг дарга |
| | Орхон сумын Засаг дарга |
| | Хонгор сумын Засаг дарга |
| | Дархан хотын хог тээвэр ОНӨААТҮГ-ын дарга |
| | Хөдөө аж ахуйн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбарын Шинжлэх ухаан хамтын ажиллагааны албаны дарга |
| | Найрамдал төслийн удирдагч |
| Нарийн бичгийн дарга: | Захирагчийн ажлын албаны дарга |

2.Журмыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, батлуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ажлын хэсэг (Я.Бат-Очир)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01-А/373 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

## АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3. /энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг батлах, мөрдүүлэх/, 9.1.4. /нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах/ тухай хуулийн хэрэгжилт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд болон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх журам, тарифыг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны [illegible] дугаар захирамжаар байгуулсан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах зарчмыг баримтлан журмыг боловсруулла. Үүнд:

1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах
2. Хамгийн бага хэмжээгээр булах /шинэ технологи, инноваци нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх/
3. Салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах
4. Төрийн ажил үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжээр гүйцэтгүүлэх боломжийг бий болгох
5. Хяналтын тогтолцоог сайжруулах

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-д заасны дагуу журмын төсөлд иргэдээс санал авах хэлэлцүүлгүүдийг аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимаар дамжуулан 2022, 2025 онуудад аймгийн хэмжээнд /Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдын ЗДТГ, ИТХ-ын ажлын албатай хамран/ зохион байгуулж иргэд, мэргэжлийн байгууллага, холбоод, төрийн бус байгууллагуудын саналыг хүлээн авах, тусгах ажлыг зохион байгуулсан. Мөн иргэдийн саналыг цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж 344 иргэн хандаж, 5 иргэн саналаа ирүүлснийг журмын төсөлд оруулсан болно.

Журам батлагдсанаар айл өрх, аж ахуй нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулж тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх зэрэг үйл ажиллагаат эрхлэхэд үүсэх харилцааг ойлгомтой болгож, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, шинэ техник, технологи нэвтрүүлэх, үүрэг хариуцлагыг илүү хяналттайгаар хэрэгжүүлэх боломжууд нэмэгдэж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа уг салбарт шинэ түвшинд гарна гэж үзэж байна.

Ажлын хэсгийн дарга [signature] Я.Бат-Очир

---

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ТӨСӨЛ ХЯНАХ ХУУДАС**

2025 оны 08 сарын 04 өдөр №  Дархан

1. Төсөл боловсруулсан албан тушаалтны нэр: Аймгийн Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргил
2. Журмын нэр: "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам" төсөл
3. Төсөлд санал, дүгнэлт, зөвлөмж өгөх албан тушаалтан

| Хяналт тавих албан тушаалтан | Он, сар, өдөр | Өгсөн санал, дүгнэлт, зөвлөмж /Санал, дүгнэлт, зөвлөмж өгсөн, өгөөгүй талаар заавал тэмдэглэл хийнэ/ | Гарын үсэг |
|---|---|---|---|
| ХЯНАХ | | | |
| Хууль, эрх зүйн хэлтсийн дарга | [illegible] | [illegible] | [signature] |
| САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ | | | |
| Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн | | Ашиг сонирхлын зөрчилгүй талаар илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах:<br>• Шаардлагатай /доогуур нь зурах/<br>• Шаардлагагүй /доогуур нь зурах/ | |

4. Төсөлд өгсөн санал, дүгнэлт, зөвлөмжийн маргаантай асуудлыг шийдвэрлэсэн, талаарх тэмдэглэл

---

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮС ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ТӨСӨЛ ХЯНАХ ХУУДАС**

2025он .... сарын .... өдөр №  Дархан

1. Төсөл боловсруулсан албан тушаалтны нэр: Аймгийн Захирагчийн ажлын албаны дарга Б.Оргил
2. Төслийн нэр: "Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах тухай"
3. Төсөлд санал, дүгнэлт, зөвлөмж өгөх албан тушаалтан

| Хяналт тавих албан тушаалтан | Он, сар, өдөр | Өгсөн санал, дүгнэлт, зөвлөмж /Санал, дүгнэлт, зөвлөмж өгсөн, өгөөгүй талаар заавал тэмдэглэл хийнэ/ | Гарын үсэг |
|---|---|---|---|
| ХЯНАХ | | | |
| Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс /Аймгийн ерөнхий эдийн засагч/ | 2025/08/04 | Саналгүй | [signature] |
| САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ | | | |
| | | | |

5. Төсөлд өгсөн санал, дүгнэлт, зөвлөмжийн маргаантай асуудлыг шийдвэрлэсэн, талаарх тэмдэглэл

## ДУА-ийн Засаг даргын 01-А/373 захирамжийн ажлын хэсгийн хуралдаан, санал авах арга хэмжээнүүд /Цахим сайтад 2557 хандалт үүсэж, саналаа илэрхийлсэн/.









# ДУА-ийн ИТХ-ын иргэний танхимаар иргэд, БИНХ-ын дарга зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авах арга хэмжээнүүд








Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн хүрээнд дахин аймгийн ИТХ-ын Иргэний танхимтай хамтран **“Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф батлах тухай”** төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

http://darkhan uul.khural.mn/forum/ цахим сайтад журмын төслийг 2025.04.29-ний өдрөөс нэг сарын хугацаатай байршуулахад 545 иргэн хандаж 5 санал ирсэн.







